

# Таваарын зах зээлийн долоо хоногийн тойм

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.02.14

Нүүрс  
Төмрийн хүдэр  
Зэс



# НҮҮРСНИЙ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 02-р сарын 14

## Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн мягмар гарагт БНХАУ-ын Далианы таваарын биржийн коксжих нүүрсний 5 сарын гэрээний ханш ханш 7.6 хувиар өсөж 2,470 юань /388.25 ам.доллар/ хүрч 10 сарын 27 өдрөөс хойшхи нэг өдрийн доторхи хамгийн өндөр өсөлтөө үзүүлжээ. Харин Zhengzhou-ийн таваарын биржид арилжаалагдаж буй дулааны нүүрсний ханш 10 хувиар өссөн байна.

GF Futures-ийн шинжээчийн мэдэгдсэнээр 2 сард коксжих нүүрсний импорт буурсан. Ялангуяа боомтууд дээрх Австралийн коксжих нүүрсний нөөц буурсан байна. Мөн тэрээр ган хайлуулах үйлдвэрүүдийн үйл ажиллагаа эрчимжиж байгаа үед нийлүүлэлт удааширч буй нь зах зээлд хомсдол үүсгэх эрсдэлтэйг сануулав.

Тус өдөр Далианы таваарын бирж дэх ган үйлдвэрлэлийн голлох орц материалуудын үнэ өссөн бөгөөд үүнд металургийн коксын ханш 4.4 хувиар өсөж 3,133 юаньд хүржээ.



Харин Шанхайн таваарын биржид арилжаалагдаж буй арматурын ханш 1.6 хувиар өсөж 4,912 юаньд хүрсэн бол цувимал ороомгийн ханш 2.1 хувиар өсөж 5061 юаньд хүрсэн байна.

БНХАУ-ын засгийн газраас 12 сараас хойш өсөөд буй дулааны нүүрс болон коксжих нүүрсний ханшийг тогтворжуулна гэж өнгөрсөн долоо хоногт мэдэгдсэн бөгөөд харин ямар арга замаар ханшийг тогтворжуулах талаар тодорхой мэдээлэл хэлээгүй байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



# ТӨМРИЙН ХҮДРИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 02-р сарын 14

## Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт БНХАУ-ын Далианы таваарын биржид арилжаалагдаж буй төмрийн хүдрийн 5 сарын гэрээний ханш 812.5 юань дээр нээгдэж баасан гарагт 833.5 юань дээр хаагдсанаар 2.6 хувийн өсөлт үзүүлээ.

Мөн БНХАУ-ын засгийн газар гангийн салбарт ногдоод байсан агаарын бохирдлыг бууруулах зорилтоо 5 жилээр хойшлуулсан байна. Гангийн салбар нь БНХАУ-ын нийт агаарын бохирдлын 15 хувийг бүрдүүлдэг бөгөөд тус салбарын агаарын бохирдлыг бууруулах зорилтуудыг 2025 оноос 2030 он хүртэл хойшлуулсан байна.

Mysteel-ийн шинжээч Xu Xiangchun-ийн мэдэгдсэнээр энэхүү өөрчлөлт нь гангийн салбарт томоохон боломжийг өгч байгаа бөгөөд агаарын бохирдлыг бууруулахын тулд хэрэгжүүлэх хэт хатуу зорилтууд нь эдийн засагт ихээхэн хохирол үзүүлэх байсан хэмээжээ.

Published on Investing.com, 14/Feb/2022 - 1:03:30 GMT, Powered by TradingView.

Iron ore fines 62% Fe CFR Futures, China, DCE:DCIOK2, D



Энэ мэдээллийн улмаас гангийн салбарын ихэнх орц материалуудын үнэ өссөн бөгөөд шинжээчид БНХАУ-ыг агаарын бохирдлыг бууруулах 2030 он хүртэлх зорилтоо биелүүлэх боломжгүйд хүрэх вий гэж сэрэмжилж байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



# ЗЭСИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Долоо хоногийн онцлох үйл явдал

2022 оны 2-р сарын 14

Өнгөрсөн долоо хоногийн даваа гарагт Шанхайн таваарын биржид арилжаалагдаж буй зэсийн 11 сарын гэрээний ханш 71,010 юань дээр нээгдэж баасан гарагт 72,320 юань дээр хаагдсанаар 1.8 хувийн өсөлт үзүүлсэн байна.

Өнгөрсөн долоо хоногийн лхагва гарагт таваарын биржүүд дэх зэсийн агуулахын нөөцүүд түүхэн доод хэмжээндээ дахин хүрчээ. Тодруулбал, дэлхийн нийт таваарын биржүүд дэх нөөцийн талаас илүүг нь бүрдүүлдэг Лондонгийн металын бирж, Нью-Йоркийн Comex, Шанхайн SHFE зэрэг биржүүдийн нөөц түүхэн доод буюу 200,402 тоннд хүрсэн байна.

Үүнтэй холбоотойгоор тухайн өдөр Шанхайн таваарын биржид арилжаалагдаж буй зэсийн спот ханш 4 хувиар өсөж 2021 оны 10 сараас хойшхи хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн бол Нью-Йоркийн Comex таваарын биржид арилжаалагдаж буй зэсийн 3 сарын гэрээний ханш 2.1 хувиар өсөж 4.7065 ам.долларт хүрснээр 10 сараас хойшхи хамгийн том өсөлтийг үзүүлжээ.

Published on Investing.com, 14/Feb/2022 - 1:16:15 GMT, Powered by TradingView.

Copper Futures, China, SHFE:SCF1, D



ANZ Group-ийн стратегич “Голлох таваарын биржүүдийн зэсийн нөөц дэлхийн нийт хэрэглээний гуравхан өдрийн хэрэгцээг хангахуйц түвшинд байгаа бөгөөд энэ нь маш аюултай нөхцөл байдал юм” гэсэн байна.

Таваарын зах зээлийн эксперт, эдийн засагч Patricia Mohr “Зэсийн ханш цаашид дунд хугацаандаа дахин нэг удаа супер цикл үзүүлэх боломжтой бөгөөд паунд нь 5 ам.доллар хүртэл өсөх боломжтой” гэжээ.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.